



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 07/34


Булган

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
хуралдааны дэг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.9, 48 дугаар зүйлийн 48.1, 52 дугаар зүйлийн 52.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. "Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг"-ийг хавсралтаар баталсугай.
2. Хуралдааны дэгийг мөрдөж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд даалгасугай.
3. Энэ тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Э.Бүжмаа)-д даалгасугай.
5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн 01/04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА *Ж.Долоон-од* Ж.ДОЛООН-ОД



0719099